



УРИАЛГА

Аймгийн Засаг даргын А/68 дугаар захирамжаар 2022 оныг “Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг дээшлүүлэх жил” болгон зарласан.

Төрийн албан хаагчийн “Ёс зүй, сахилга хариуцлагыг өндөржүүлж, мэргэшсэн төрийн албыг төлөвшүүлэх аян”-ийг Аймгийн Засаг даргын баталсан удирдамжийн дагуу 2022 оны 10 дугаар сарын 17-ний өдрөөс 11 дүгээр сарын 17-ний өдрийн хооронд албан байгууллагууд хэрэгжүүлэн ажиллаж байна.

Иймд ажилтан албан хаагчид та бүхэн тус аяны үйл ажиллагаанд идэвх санаачилгатай оролцож байгууллагын Ёс зүйн зөвлөлөөс зохион байгуулж буй үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэн хамтран ажиллахыг уриалж байна.

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗАР
ЁС ЗҮЙН ЗӨВЛӨЛ